

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2008 оны 2 дугаар сарын
20-ны өдөр

Улаанбаатар
хот

Дугаар 64

ТӨЛӨВЛӨГӨӨ БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Ноолуурын салбарт 2012 он хүртэл хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хавсралтын ёсоор баталсугай.
2. Арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг Засгийн газрын тусгай сангийн зээлийн хөрөнгөөр санхүүжүүлэх, гадаад орон, олон улсын байгууллагад санал болгох замаар шийдвэрлэхийг Үйлдвэр, худалдааны сайд Х.Наранхүү, Сангийн сайд Ч.Улаан, Хүнс, хөдөө аж ахуйн сайд Ц.Ганхуяг нарт даалгасугай.
3. Төлөвлөгөөний биелэлтийн явц, үр дүнг жил бүрийн I улиралд багтаан Засгийн газарт танилцуулж байхыг Үйлдвэр, худалдааны сайд Х.Наранхүүд даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД

С.БАЯР

ҮЙЛДВЭР, ХУДАЛДААНЫ САЙД

Х.НАРАНХҮҮ

**НООЛУУРЫН САЛБАРТ 2012 ОН ХҮРТЭЛ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА
ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	Зорилго	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Шаардлагатай хөрөнгө (сая төгрөг)					Хэрэгжилтийг зохицуулах, хяналт тавих байгууллага
				2008	2009	2010	2011	Эх үүсвэр	
I. Хууль эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох хүрээнд									
1	Өрсөлдөх чадвар бүхий бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжихэд чиглэсэн эрх зүйн таатай орчин бүрдүүлэх	1. Дэлхийн худалдааны байгууллагын өмнө Монгол Улсын хүлээсэн үүрэг амлалтын хүрээнд бохир ноолуурын экспортын татварыг шинэчлэн тогтоох тухай хуулийн төслийг хэлэлцүүлэх	2008	-	-	-	-	-	ҮХЯ МННХ
		2. Үйлдвэрлэл технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийг хэлэлцүүлэх арга хэмжээ авах	2008	-	-	-	-	-	ҮХЯ
		3. Дотоодод үйлдвэрлэж байгаа ноолууран утас, сүлжмэл, нэхмэл бүтээгдэхүүнтэй ижил нэрийн барааны импортын татварыг нэмэгдүүлэх асуудлыг судалж боловсруулах	2008	-	-	-	-	-	ҮХЯ МННХ

2	Түүхий эд бэлтгэлийн тогтолцоог боловсронгуй болгох, зах зээлийн зарчимд нийцсэн түүхий эдийн бирж байгуулах эрх зүйн үндэс боловсруулах	1. Түүхий эдийг биржээр дамжуулан худалдаалах механизмыг бүрдүүлэх	2008-2009	12.0	10.0	10.0	-	Зээл, тусламж	ХХААЯ ҮХЯ
		2. Олон улсын болон Монгол Улсын стандартын шаардлага хангасан боловсруулалт хийсэн түүхий эдийг экспортлох механизмыг бүрдүүлэх	2008-2009	-	-	-	-	Зээл, тусламж	ҮХЯ УТЕГ МННХ
		3. Түүхий эдийн экспортод тавих хөндлөнгийн хяналтыг сайжруулах, хууль бус экспортыг зогсоох	2008-2011	10.0	10.0	10.0	-	Төсвийн болон үйлдвэрийн зардал	ҮХЯ УТЕГ УМХГ МННХ
II. Ээрэх нэхэх, сүлжих хүчин чадлыг нэмэгдүүлэн түүхий эдийг дотооддоо бүрэн боловсруулж, эцсийн бэлэн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэн өргөжүүлэх замаар ноолуур боловсруулах цогцолбор буюу аж үйлдвэрийн парк байгуулах зорилтын хүрээнд									
3	Эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжих	1.Түүхий эдийн нөөцтэй уялдуулан бөмбөгөн ноолуур, ээрэх, сүлжих, нэхэх шат дамжлагыг өргөтгөх үйл ажиллагаанд бодлогын дэмжлэг үзүүлэх	2008-2011	57000.0	40500.0	20000.0	20000.0	Хөрөнгө оруулалт, зээл, тусламж	ҮХЯ СЯ МННХ
		2. Ноолуур боловсруулах үйлдвэрлэлийг цогцолбор болгон хөгжүүлж бэлэн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн өсөлтийг хангах	2008-2011	250.0	120.0	-	-	Хөрөнгө оруулалт, зээл, тусламж	ҮХЯ СЯ МННХ
		3. Эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг компаниудад түүхий эдийн бэлтгэлд нь зориулан олгох хөнгөлөлттэй зээлийн сан бий болгох асуудлыг судлах	2008-2010	-	-	-	-	-	ҮХЯ СЯ

4	Үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлэх тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, химийн болон бусад туслах материалыг импортлох үйл ажиллагааг эдийн засгийн аргаар дэмжих	1. Ноолуур боловсруулах үйлдвэрлэлийг тэргүүлэх салбарын жагсаалтад оруулж, технологийн шаардлагатай тоног төхөөрөмж, үндсэн болон туслах материал импортлоход татварын хөнгөлөлт үзүүлэх асуудлыг судалж боловсруулах	2008-2009	-	-	-	-	-	ҮХЯ СЯ МННХ
5	Эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж байгаа болон анхан шатны боловсруулах үйлдвэрүүдийг Татварт бүрэн хамруулах	1. Анхан шатны боловсруулах үйлдвэрүүдийг аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татварт бүрэн хамруулах санал боловсруулах, тэдгээрийн үйл ажиллагаанд хяналт тавих	2008	-	-	-	-	-	ҮХЯ СЯ УМХГ МННХ
		2. Үйлдвэрүүдийн зүгээс үйлдвэрлэлийн нөхцөлд тавигдах шаардлага, стандартын үзүүлэлтийг хангуулах арга хэмжээг авч ажиллах	2008	-	-	-	-	-	ҮХЯ УМХГ МННХ
6	Салбарын хүний нөөцийн чадавхийг дээшлүүлэх	1. Технологич, загвар зохион бүтээгч зэрэг мэргэжлээр боловсон хүчин бэлтгэх, давтан сургаж мэргэшүүлэх арга хэмжээ авах	2008-2012	-	-	-	-	-	ҮХЯ БСШУЯ
		2. Мэргэжилтэй ажилчин бэлтгэх арга хэмжээ авах	2008-2012	-	100.0	100.0	100.0	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан, төсөв	ҮХЯ, НХХЯ СЯ, МННХ
III. Бүтээгдэхүүний чанар, загварыг сайжруулж нэр төрлийг олшруулах, экспортыг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд									
7	Ноолуур боловсруулах үйлдвэрийн техник, технологийн түвшинг үнэлэх	1. Технологи дамжуулах хууль болон бусад хууль тогтоомжийн хүрээнд ноолуур боловсруулах үйлдвэрийн техник, технологийн түвшинг үнэлэх	2008-2009	-	-	-	-	-	ҮХЯ МННХ

8	Шаардлагатай үндэсний стандартуудыг боловсруулах	1. Тухайн чиглэлээр холбогдох судалгаа хийж дүгнэлт гаргах	2008-2012	-	-	-	-	-	ҮХЯ МННХ
		2. Стандартын төслүүдийг боловсруулж санал авах							ҮХЯ МННХ
		3. Стандартын төслүүдийг Техникийн хороогоор хэлэлцүүлэх							ҮХЯ МННХ
		4. Стандартын төслүүдийг Стандартчилал, хэмжил зүйн төвийн зөвлөлөөр хэлэлцүүлэх							СХЗТ
9	Эрдэм шинжилгээний байгууллагын техник, тоног төхөөрөмжийг шинэчлэх	1.Нэхмэлийн хүрээлэнгийн лабораторийг сүүлийн үеийн тоног төхөөрөмжөөр иж бүрэн шинэчлэх арга хэмжээ авах	2008-2009	200.0	200.0	200.0	200.0	Зээл, тусламж	ҮХЯ СЯ
10	Ноолуурын салбарын өрсөлдөх чадварын судалгаа	1. Салбарын өрсөлдөх чадварыг тодорхойлох өрсөлдөгч орнуудтай харьцуулсан судалгаа хийж байх	2008-2012	-	-	-	-	-	ҮХЯ
		2. Ноолуурын зах зээл, хэрэглэгч, бүтээгдэхүүний нийлүүлэлт болон гадаадын өрсөлдөгчийн судалгааг тогтмол хийж байх	2008-2012	-	-	-	-	-	ҮХЯ
11	Оны шилдэг загвар, бүтээгдэхүүн, загвар зохион бүтээгч, үйлдвэрлэгч шалгаруулж урамшуулах	1. Оны шилдэг загвар, бүтээгдэхүүн, загвар зохион бүтээгч, үйлдвэрлэгч шалгаруулах ажлыг зохион байгуулах	2008-2011	-	-	-	-	-	МННХ ҮХЯ
		2. Экологийн цэвэр, чанартай ноолууран бүтээгдэхүүн үйлдвэрлэх хөдөлгөөнийг өрнүүлэх	2008-2011	-	-	-	-	-	МННХ ҮХЯ

12	Олон улсын зах зээлд монгол ноолуурын чанарыг таниулах, чанарын шаардлага хангасан монгол “брэнд” бүтээгдэхүүнийг бий болгох	1. Олон улсын борлуулалтын сүлжээний шаардлагад нийцсэн “брэнд” бүтээгдэхүүн үйлдвэрлэх нөхцөлийг бий болгох	2008-2011	-	-	-	-	-	МННХ ҮХЯ
		2. Монгол ноолууран бүтээгдэхүүнийг сурталчлах, чанарын тэмдэгтэй болгох зорилго бүхий үйл ажиллагааг гадаадын мэргэжлийн байгууллагуудын оролцоотойгоор хэрэгжүүлэх	2008-2012	50.0	70.0	70.0	70.0	Зээл, тусламж	ҮХЯ СЯ МННХ МУХАҮТ
		3. Эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийг олон улсын стандарт (ISO)-ын шаардлага хангуулах чиглэлээр холбогдох арга хэмжээ авах	2008-2012	-	-	-	-	-	ҮХЯ СХЗТ МННХ
IV. Түүхий эдийн чанарыг сайжруулах, бэлтгэлийн системийг боловсронгуй болгох хүрээнд									
13	Ямаан сүргийн бүтцийг оновчтой болгох, ноолуурын чанарыг сайжруулах	1. Сүргийн бүтэц, ноолуурын чанарыг сайжруулах арга хэмжээг малын чанар, үржлийн ажлыг сайжруулах чиглэлээр хэрэгжиж байгаа хөтөлбөр, төслийн хүрээнд хэрэгжүүлэх	2008-2011	-	-	-	-	-	ХХААЯ ҮХЯ МННХ
		2. Ямаанд зориулалтын будгаар “тэмдэглэгээ” тавихыг дэмжих	2008-2011	200.0	200.0	100.0	-	Зээл, тусламж	ХХААЯ ҮХЯ МННХ
	ДҮН			57722.0	41210.0	20490.0	20370.0		

Тайлбар: МННХ – Монголын ноос ноолуурын холбоо